

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын  
даргын 2023 оны 98 тоот тушаалын  
6 дугаар хавсралт

Эдийн засгийн загварчлал хариуцсан ахлах мэргэжилтэн, Наранцогт Наранцацралт

### 2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

#### НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
3.1. Макро эдийн засгийн судалгааг хийж, эдийн засгийн тэнцвэрт байдал, үр ашгийг нэмэгдүүлэх бодлогын тэргүүлэх чиглэлийг тодорхойлох;							
1	Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, бодлого зохицуулалтаар хангана.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 35 дугаар тогтоол "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө" батлагдсан.	Монгол Улсын 2026 оны эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлж танилцуулгад тусгах. /1 танилцуулга /	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний тесөлд хөдөө аж ахуйн салбарын авч хэрэгжүүлэх шаардлагатай дараах бодлогын арга хэрэгслийг боловсруулан Хөгжлийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн. Үүнд: Салбаруудын хүчин чадлыг тэлж, өрсөлдөөнийг нэмэгдүүлэх чиглэлд: 1. Хөдөө аж ахуйн салбарын үр ашгийг дээшлүүлж, боловсруулалтын түвшнийг ахиулна. 1.1. Мал, амьтны халдварт болон гоц халдварт өвчний дэгдэлтээс	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

сэргийлэх хүрээнд вакцины  
нийлүүлэлтийг тасралтгүй  
хангах тогтолцоог  
бэхжүүлнэ.

1.2.

Бэлчээрийн даацыг  
тэнцвэрт түвшинд хадгалах,  
эрчимжсэн болон нүүдлийн  
мал аж ахуйг хослуулан уур  
амьсгалын өөрчлөлтөд  
дасан зохицсон бүтээмжит  
мал аж ахуйн салбарыг  
хөгжүүлнэ. 1.3. Төрөөс  
олгож буй урамшуулал,  
дэмжлэгийг эцсийн үр дүнд  
чиглүүлж, оновчтой болгоно.  
1.4. Хөдөө аж ахуйн  
бүтээгдэхүүний

боловсруулалтын түвшнийг  
ахиулна. 1.5. Төрөөс

үзүүлэх дэмжлэгийг  
оновчтой болгох хүрээнд  
хүнсний бүтээгдэхүүний  
хангамж, аюулгүй байдлыг  
хянах, бүртгэх цахим  
системийг бий болгоно. Мөн  
Макро эдийн засгийн  
тогтвортой байдлыг  
хадгалах чиглэлд: Төсвийн  
орлогын тогтвортой байдал,  
төсвийн суурийг нэмэгдүүлэх  
чиглэлд аж ахуйн нэгжийн  
татварын хувь хэмжээг  
ажиллагчдын тоотой  
уялдуулан хөнгөлөх  
бодлогыг хэрэгжүүлэх  
бодлогын саналыг  
боловсруулж хүргүүлсэн.

Хавсралт: 1 файл

3.2. Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах бодлогыг тодорхойлох, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл гаргах;

2	Монгол Улсын 2026 оны хөгжлийн төлөвлөгөө боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөллийн танилцуулгыг боловсруулна.	Эдийн засгийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох	-	Эдийн засгийн 2026 оны тооцоо төсөөлөл, танилцуулга бэлтгэх /1 танилцуулга/	Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд 2026 оны төсөөллийг хийж, танилцуулгад тусгасан. Үүнд: 2025 оны эдийн засгийн өсөлтийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны төсөөллийг эцэслэн тодорхойлсон. Үүнд, хөдөө аж ахуй (ХАА), барилга, боловсруулах салбарын төсөөллийг мэргэжлийн холбоод, салбар яамны албан хаагч, томоохон аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй уулзаж, төсөөлел боловсруулахад ашиглах мэдээллийн бааз суурийг өргөтгөн ажилласан. Тухайлбал, барилгын салбарын хөрөнгө оруулалтыг улс, хувийн хэвшлийн хэлбэрээр ялган тодорхойлж, томоохон төсөл хөтөлбөрүүдийн нөлөөг нарийвчлан тооцон оруулсан. Мөн ХАА-н салбарын төсөөллийг 2022, 2023 оны зудын онцгой нөхцөл байдалтай уялдуулан 21 аймгийн хэмжээнд таван хошуу малын төрөл тус бүрээр хур тунадасны хэмжээ, цасны зузаан зэрэг цаг агаарыг илэрхийлэх үзүүлэлттэй уялдуулан 2025 оны жилийн	4-р сар, 5-р сар	100%
---	---	---	---	---	--	------------------	------

					Эцсийн том малын эүй бус хорогдол, хүнсэнд хэрэглэх мал, хээлтэгч мал, төл бойжилт, нийт малын тооны төсөөллийг боловсруулж, 2024 онд хийсэн арга зүйг гүнзгийрүүлэн сайжруулсан. Боловсруулах салбарын төсөөллийг боловсруулахдаа томоохон аж ахуйн нэгжийн бизнесийн төлөвлөгөө, мэргэжлийн холбоодын үйл ажиллагааны төлөвлөгөө, зах зээлийн хүлээлттэй уялдуулан боловсрууллаа. Түүнчлэн, аж ахуйн нэгжүүдэд тулгамдаж буй бодлогын шинжтэй асуудлуудын талаар нээлттэй санал солилцож, эдийн засгийн өсөлтийг хангахад шаардлагатай бодлогын боломжит зөвлөмжийг боловсруулсан. “Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуулийн хугацаанд УИХ-д өргөн мэдүүлж өргөн мэдүүлж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр УИХ-аар батлагдлаа.	Хавсралт: 1 файл		
3	Эдийн засгийн нөхцөл байдалд улирал (Macroeconomic	Танилцуулгын тоо	Өмнөх онуудад эдийн засгийн нөхцөл	2025 оны I, II улиралд дүн шинжилгээ	2024 оны VI улирлын макро эдийн засгийн нөхцөл байдлын шинжилгээний	3-р сар, 6-р сар, 9-р сар, 12-р	100%	

	diagnostics) тутам дүн шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэнэ.	байдалд дүн шинжилгээ хийж, улирал бүр тайлан бэлтгэсэн.	хийж танилцуулга бэлтгэсэн байна. /2 танилцуулга/	(Macro diagnostics) тайлан боловсруулах, 2025 оны I улирлын тайланг эцэслэх ажил үргэлжилт байна. Тус тайландаа хөдөө аж ахуй, боловсруулах, мэдээлэл холбоо, санхүү болон даатгалын үйл ажиллагаа, барилга, үл хөдлөх зэрэг салбаруудын үйлдвэрлэлийн аргаар тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний гүйцэтгэлд тулгуурлан нөхцөл байдлын шинжилгээ хийж тайлагнав. Түүнчлэн, үйлдвэрлэлийн функцийн арга, калманы шүүлтүүрийн арга, ходрик фрескотын аргад үндэслэн эдийн засгийн потенциал өсөлт, бодит өсөлтийг тодорхойлж 2024 оны 4 дүгээр улирлын үйлдвэрлэлийн зөрүүг тооцож удирдлагад танилцуулан тайланд тусгасан. Үүнээс олон хувьсагчийн Калманы шүүлтүүрийн аргаар тооцон гаргасан бодит хүү, бодит ханш, үйлдвэрлэлийн бодит ахиу зардал, хүлээгдэж буй инфляцад тулгуурлан богино хугацааны төсөөллийн туршилтын тооцоог хийж гүйцэтгэв. Ингэснээр цаашид GAP загварт тулгуурлан богино хугацааны төсөөллийг боловсруулах арга зүй бэхжих үр нэлэөтэй	сар	

					байна. Хавсралт: 2 файл		
3.3. Эдийн засгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, эдийн засагт тулгарч болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлох;							
4	Монгол Улсын эдийн засагт тохиолдож болзошгүй гадаад, дотоод эрсдэлийг тодорхойлж дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгана.	Танилцуулгад туссан тоо.	2024 онд батлагдсан бодлогын баримт бичигт эдийн засагт тохиолдолж болзошгүй эрсдэлийг тодорхойлж тусгасан.	Болзошгүй эрсдэлийг тодорхойлж, бодлогын баримт бичгүүдийн танилцуулгад тусгасан байна. /1 танилцуулга/	Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төслийг боловсруулахдаа эдийн засгийн өсөлтийг 2026 онд 6.0 хувь, 2027-2028 онд тус тус 6.5 хувь байхаар тооцож, тусгасан бөгөөд эдийн засгийн өсөлт, төсвийн орлогод учирч болзошгүй Эрсдэлийн тайланд Уур амьсгалын өөрчлөлтийн бүлгийг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, байгаль, цаг уурын өөрчлөлтийн нөлөөгөөр зуд, үер зэрэг гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж, гамшигийн улмаас учирсан хохирлын хэмжээ нэмэгдэх өсөх хандлагатай байна. Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрсэнтэй холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар суулийн 2 жил дараалан агшаад байна. Цаг агаарын таагуй нөхцөл байдлаас өндөр хамааралтай хөдөө аж ахуйн салбарт зудын эрсдэл нэмэгдэж, хаваржилт хүндрэх, зуншлага тааруу	4-р сар, 10-р сар	100%

					байх, ган тохиолдох эрсдэл өндөр байна. Энэ нь хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл, өрхүүдийн орлого буурах, орлогын тэгш бус байдал нэмэгдэх, дотоодын хүнсний инфляц нэмэгдэхэд нөлөөлж болзошгүй байгаа талаар тусган оруулсан. Хавсралт: 1 файл		
5	Макро эдийн засгийн голпох үзүүлэлтүүдийн статистикийн сарын гүйцэтгэлээр танилцуулга бэлтгэн, удирдлагыг тухай бүр мэдээллээр хангана.	Танилцуулгын тоо	2024 онд сар бүр танилцуулга бэлтгэсэн.	2024 оны 1-6 сард танилцуулга бэлтгэсэн байна./6 танилцуулга/	Сарын танилцуулгад эдийн засгийн өсөлт, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнийн индекс, боловсруулах салбарын үйлдвэрлэлийн хэмжээ болон гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээг хариуцан ажиллаж байна. 2025 оны 3 дугаар сарын тайландаа барилгын салбарын орц бүтээгдэхүүн болох цемент, катодын зэс, метал бэлдэц, цувимал, вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн хэмжээг тусган оруулсан. Тус мэдээ нь сар бүр яамны цахим хаяг дээр тогтмол нийтлэгдэж олон нийтийг мэдээллээр хангаж байна. Хавсралт: 1 файл	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

3.5. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах, олон нийтэд

ХЭЛЭЛЦҮҮЛЭХ;								
6	Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад шаардлагатай макро эдийн засгийн болон төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн тооцоо, төсөөлөл, танилцуулгыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, УИХ-д өргөн мэдүүлнэ.	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль	Тооцоо, төсөөллийн танилцуулгын тоо	"Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2025.04.23-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд 19 дугаар тэмдэглэлд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтосоны дагуу 2025.04.30-ны өдөр "Монгол Улсын нэгдсэн төсвийн 2026 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027-2028 оны төсвийн төсөөллийн тухай" хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгаланд өргөн мэдүүлж, 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан. Тус хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбоотойгоор Төсвийн байнгын хороо, Улсын Их хурлын нэгдсэн чуулганы анхны хэлэлцүүлэгт хэлэлцүүлэхэд төсвийн тооцоолол, танилцууллагыг бэлтгэж удирдлагад хүргүүлж ажилласан. Тус төсөлд хөдөө аж ахуй, боловсруулах, барилга зэрэг салбаруудын нөхцөл байдлын дэлгэрэнгүй	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар	100%	

					шинжилгээ хийж, 2025 оны эдийн засгийн өсөлтийн хүлээгдэж буй гүйцэтгэл, 2026 оны тесөөллийг эцэслэн удирдлагад танилцуулж, танилцуулгад тусгасан. Мөн олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийн зохион байгуулалтад оролцож ажилласан.		
					Хавсралт: 1 файл		

## НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	

### 4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх

1	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа	-	Газрын чиг үүрэгт заасан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх хүрээнд өөрийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалт, семинарт хамрагдаж, ур чадвараа	Макро эдийн засгийн эрсдэл, эмзэг байдал, хямралд хүрч болзошгүй нөхцөл байдлын шинжилгээ хийх арга зүйг бэхжүүлэх хүрээнд Олон Улсын Валютын Сангийн Австри Улсын нийслэл Виенна хот дах чадавх бэхжүүлэх сургалтын институцээс 2025	6-р сар, 12-р сар	100%
---	--	--	---	--	---	-------------------	------

	хөгжүүлэх	дээшлүүлсэн байх		дээшлүүлсэн байх	онд зохион байгуулсан Vulnerability Diagnostics буюу эмзэг байдлын шинжилгээ сургалтад дэлхийн 10 орны дунд түвшний мэргэжилтнүүдийн хамт амжилттай суралцаж, сертификат хүлээн авсан. Хавсралт: 1 файл		
2	Албан хаагчдад мэдээлэл түгээх, санал, солилцох зорилготой "Мэдээллийн цаг"-т оролцсон байна.	Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байх.	-	Яамны "Мэдээллийн цаг"-т оролцсон байна.	Улсын Их Хурлын чуулганы хуралдаан, Засгийн газрын хуралдаан, албан томилолт, чөлөөнөөс бусад үед тухай бүрд сургалтад хамрагдаж мэдээ, мэдээллийг авч ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

ТАЙЛАН ТАНИЛЦСАН:

Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Л.Энх-Амгалан



Огноо: .....

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эдийн засгийн загварчлал хариуцсан ахлах мэргэжилтэн, Н.Наранцацралт

..... /  
Н.Наранцацралт

Огноо: 2025.06.25